



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 4/240

Өмнөдэлгэр сум

Байгалийн баялаг ашиглах
нөхөн сэргээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын журам батлах тухай 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн автозамаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай автозам барихад ашиглах чулууны карьерыг тус сумын Гурванбаян тосгонд автозам гүүрийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглаж техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж орон нутагт хүлээлгэн өгөхийг “Тэргүүн саруул зам” ХХК-ийн захирал (Т.Энхсайхан)-д даалгасугай.

2.Карьерыг ашиглах явцад байнгын хяналт тавьж түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж зам барилгын ажил дуусмагц нөхөн сэргээлтийг хийлгэж талбайг хүлээн авахыг Гурванбаян тосгоны Татварын байцаагч (Л.Ганцогт), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Баярсайхан) нарт үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР